



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталж 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байгаа "Төрийн албаны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн 66.1.8 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5 дахь хэсэгт заасныг баримтлан Төрийн албаны зөвлөлөөс бүх шатны төрийн захиргааны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтанд дараах 3 чиглэлээр албан даалгаврыг хүргүүлж байна.

**1. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар**

Ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр эцэслэн тогтоогдсон төрийн албан хаагчийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөн олгох. Хэрэв ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нөхөн төлөөгүй бол хууль бус шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх.

**2. Томилгооны зөрчил арилгах талаар**

Төрийн албаны зөвлөлөөс төрийн зарим байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудтай 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хийсэн уулзалтын үеэр тухайн байгууллагад хүний нөөцийн хууль бус томилгоо байгаа бол байгууллага, албан тушаалтанд 2019 оны 03 дугаар сарын 19-ний дотор хуульд нийцүүлэх, залруулах үүрэг чиглэл өгсөн. Үүний биелэлтийг хангаж ямар арга хэмжээ авсан тухай болон өөрийн байгууллагын хүний нөөцийн төлөв байдал, түүний нөхөн хангалтын хэрэгцээ шаардлагын талаарх мэдээ, тайланг ирүүлэх.


**3. Төрийн албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгоход гарсан зөрчлийг арилгах талаар**

Төрийн албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох шаардлагыг хангасан байхад олгоогүй эсхүл шаардлага хангаагүй албан хаагчид зэрэг дэв олгосон зэрэг зөрчлийг арилгах. Албан тушаалын зэрэг дэв олгох саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхдээ Төрийн албаны тухай хууль болон Улсын Их

Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу тухайн албан хаагчийн төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ зэргийг сайтар тооцон нягталж үзэх.

Төрийн албаны зөвлөлөөс хүргүүлж буй энэхүү албан даалгаврын биелэлтийн хэрэгжилтийн тайланг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Зөвлөлд ирүүлэх.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ